



СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ ХУРААНГУЙ

Хөвсгөл аймгийн Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/16/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: mandakhnaranL@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Т.Мөнхзул
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/257
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН
СУМЫН "ТАРИАЛАН НИЙТИЙН
АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ" ХХК-
ИЙН ЗАХИРАЛ Г.БОЛДОО ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, болон тодруулгуудад аудит хийлээ.

Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ТУЗ-аар батлагдсан орлого үр дүнгийн тайлангийн төлөвлөгөө нь оны эхэнд 999.6 сая төгрөгийн борлуулалт, 997.5 сая төгрөгийн зардалтай, 2.1 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөгдсөн ч тайлант онд 81.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нийт 151.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 88.0 сая төгрөгийн алдааг залруулж, 4.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 58.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК нь ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 001 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг батлаж, 2023 оны 10 сарын 6-ны 9 дүгээр тогтоолоор зардал хооронд зохицуулалт хийн тодотгож, 83 хувийн орлогын гүйцэтгэлтэй байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-аар батлагдсан Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд суурилж, ТУЗ бизнес төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж, баталдаг байна.

5724040530

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
		2023.01.01	2023.12.31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,557,244.15	8,211,966.47
1.1.2	Дансны авлага	88,572,519.22	36,649,911.02
1.1.4	Бусад авлага	0.00	60,000,000.00
1.1.6	Бараа материал	83,739,291.45	72,395,810.85
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	173,869,054.82	177,257,688.35
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,148,445,105.57	1,116,847,467.07
1.2.2	Биет бус хөрөнгө	22,171,720.00	22,171,720.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,170,616,825.57	1,139,019,187.07
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,344,485,880.39	1,316,276,875.42
2.1.1.1	Дансны өглөг	35,381,913.64	37,952,100.51
2.1.1.3	Татварын өр	14,320,426.89	34,039,690.96
2.1.1.4	НДШ - ийн өглөг	(0.00)	655,066.00
2.1.1.5	Хойшлогдсон татварын өглөг	51,839,045.84	45,903,874.29
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	101,541,386.37	118,550,731.76
2.2	Өр төлбөрийн нийт дүн	101,541,386.37	118,550,731.76
2.3.1	Өмч: - төрийн	367,132,300.00	367,132,300.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	668,998,445.94	635,114,945.94
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	334,530,399.00	375,662,399.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(127,716,650.92)	(180,183,501.29)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,242,944,494.02	1,197,726,143.66
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	1,344,485,880.39	1,316,276,875.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	581,770,310.09	830,175,796.82
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	516,183,247.21	837,190,218.85
3	Нийт ашиг (алдагдал)	65,587,062.88	(7,014,422.03)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	40,961,302.00	80,271,099.89
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	5,935,171.55
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	24,625,760.88	(81,350,350.37)
19	Орлогын татварын зардал	2,462,576.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	22,163,184.88	(81,350,350.37)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	22,163,187.88	(81,350,350.37)
24	Орлогын нийт дүн	22,163,187.88	(81,350,350.37)

Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	186,039,400.00	668,998,445.94	167,882,520.00	(15,064,040.78)	1,007,856,325.16
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	181,092,900.00	0.00	0.00	0.00	181,092,900.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(85,752,610.14)	(85,752,610.14)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	166,647,879.00	0.00	166,647,879.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(26,900,000.00)	(26,900,000.00)
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	367,132,300.00	668,998,445.94	334,530,399.00	(127,716,650.92)	1,242,944,494.02
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(81,350,350.37)	(81,350,350.37)
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	41,132,000.00	0.00	41,132,000.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(5,000,000.00)	(5,000,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	(33,883,500.00)	0.00	33,883,500.00	0.00
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	367,132,300.00	635,114,945.94	375,662,399.00	(180,183,501.29)	1,197,726,143.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	924,044,847.22	961,039,266.30
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	912,003,415.40	960,488,715.30
	Бусад мөнгөн орлого	12,041,431.82	550,551.00
1.2	Мөнгөн зарлага (-)	850,974,803.35	889,384,543.98
	Ажиллагчдад төлсөн	220,536,286.00	228,403,459.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	66,313,577.15	75,283,082.82
	Бараа материал худалдан авахад төлсөн	193,616,313.13	202,585,317.00
	Ашиглалтын зардалд төлсөн	59,086,949.00	106,290,476.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	210,400,228.05	173,572,488.40
	Татварын байгууллагад төлсөн	55,446,236.95	60,821,936.51
	Бусад мөнгөн зарлага	45,575,213.07	42,427,784.25
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	73,070,043.87	71,654,722.32
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	71,700,000.00	60,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	71,700,000.00	60,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(71,700,000.00)	(60,000,000.00)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,000,000.00	5,000,000.00
	Төлсөн ногдол ашиг	5,000,000.00	5,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,000,000.00)	(5,000,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,629,956.13)	6,654,722.32
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,187,200.28	1,557,244.15
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,557,244.15	8,211,966.47

Тариалан Нийтийн ахуйн үйлчилгээний төв ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 ТУЗ-аар батлагдсан бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл

/төгрөгөөр/

	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	биелэлт хувиар
1	Халаалтын орлого	938,723,089.00	754,773,325.82	(183,949,763)	80%
2	Цэвэр усны орлого	22,789,236.00	41,225,824.00	18,436,588	181%
3	Бохир усны орлого	13,840,000.00	13,529,959.00	(310,041)	98%
4	Халуун усны орлого	16,104,000.00	10,310,000.00	(5,794,000)	64%
5	Хогний төлбөрийн орлого	-	-	-	0%
6	Түрээсийн орлого	2,160,000.00	1,427,272.00	(732,728)	66%
7	Бусад орлого	6,000,000.00	8,909,416.00	2,909,416	148%
	Орлогын дүн	999,616,325.00	830,175,796.82	(169,440,528)	83%
1	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал	295,420,185.00	288,342,043.00	(7,078,142)	98%
2	НДШимтгэлийн зардал	39,881,724.90	39,765,028.00	(116,697)	100%
3	Нүүрс	112,975,280.00	112,975,280.00	-	100%
4	Шатахуун	75,379,000.00	34,365,817.00	(41,013,183)	46%
5	Тээврийн зардал	197,320,000.00	175,161,931.00	(22,158,069)	89%
6	Гэрэл цахилгаан	74,420,336.00	74,420,336.00	-	100%
7	Бичиг хэрэг	797,500.00	797,500.00	-	100%
8	Цахилгаан холбоо	744,000.00	744,000.00	-	100%
9	Албан томилолт	700,000.00	700,000.00	-	100%
10	Цэвэрлэгээний материал	12,728,000.00	6,094,091.00	(6,633,909)	48%
11	Хөдөлмөр хамгаалал	11,808,400.00	3,785,000.00	(8,023,400)	32%
12	Урсгал засвар	9,920,000.00	9,920,000.00	-	100%
13	Төлбөр хураамж	7,434,000.00	7,434,000.00	-	100%
14	ТУЗ зардал	10,285,200.00	5,030,000.00	(5,255,200)	49%
15	Түлээний зардал	3,500,000.00	3,500,000.00	-	100%
16	Хор саармагжуулах ундаа	7,920,000.00	4,238,502.00	(3,681,498)	54%
17	Сэлбэгийн зардал	28,977,220.00	44,708,783.72	15,731,564	154%
18	Үйлчилгээний тохижилт	3,115,000.00	-	(3,115,000)	0%
19	Ажилчидын нийгэм хангамж	5,630,000.00	5,630,000.00	-	100%
20	Сургалтын зардал	1,134,000.00	1,134,000.00	-	100%
21	Дахивар.Нэрлэсэн жил	3,000,000.00	3,000,000.00	-	100%
22	Угаалгын газар байгуулах	3,720,000.00	-	(3,720,000)	0%
23	Ноогдол ашиг	5,000,000.00	5,000,000.00	-	100%
24	Элэгдлийн зардал	37,215,007.00	37,215,007.00	-	100%
25	Болзошгүй зардал	45,000,000.00	50,000,000.00	5,000,000	111%
26	Нохой устгал	3,500,000.00	3,500,000.00	-	
27	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	997,524,852.90	917,461,318.72	(80,063,534)	92%
28	Үйл ажиллагааны бус орлого, зардал		5,935,171.55	5,935,171.55	0%
29	<u>Татварын өмнөх ашиг /алдагдал/</u>	<u>2,091,472.10</u>	<u>(81,350,350.37)</u>	<u>(83,441,822.46)</u>	<u>-3890%</u>

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 151.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 88.0 сая төгрөгийн алдааг залруулж, 4.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 58.3 сая төгрөгийн албан шаардлага, 1.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх нийт 2 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 6.1 сая төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 9.8 сая төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- НӨАТ тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогыг 88.0 сая төгрөгөөр илүү тайлагнасныг тайлангийн хугацаанд залруулсан.

Төлбөрийн акт

1. Томилолттой холбоотой

Илрүүлэлт: Томилолтын тооцоог мөнгөн хөрөнгийн анхан шатны баримттай тулгахад, 4 хүнд томилолтын зардал 0.2 сая төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 120-р тушаал болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

2. Тэтгэмжтэй холбоотой

Илрүүлэлт: Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн гүйцэтгэх захиралд ТУЗ-ын тогтоолыг үндэслэн тэтгэмж олгосон нь ТУЗ-ын 23 оны 8 сарын 23-ны 06 тоот тогтоол Хөдөлмөрийн тухай хуулийн 82-р зүйлийн 82.1.Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

Албан шаардлага

1. Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Худалдан авалттай холбоотой 57.7 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримттай боловч цахим и-баримтгүй байгаа нь орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “Доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” НББ-ийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1. “Анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлэв.

2. Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Хөвсгөл дуулга ХХК-тай шатах тослох материал нийлүүлэх гэрээний үнийг байгууллагын захирлын тушаалаар нэмэгдүүлэн тооцсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20.5, “Тендер

хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерийг өөрчлөх, эсхүл буцаахыг хориглоно. 41.2.Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлаагүй бол уг нэмэлт, өөрчлөлт илт хууль бус байна гэсэн заалтуудтай тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой

Илрүүлэлт: МЦХК, мобиком, юнител, скайтелд тусламж, Аймгийн чуулганд оролцох сурагчдад дэмжлэгт зориулж хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25.10 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6 “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт: Шинэчлэгдэж батлагдсан НБББББ-ын үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа нь тухайн байгууллагад ашиглагддаг дулааны шугам, барилга байгууламжийн онцлогийг харгалзан тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5.1.6 “зохицох”-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:НББББ-нд нэмэлт өөрчлөлт оруулах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дугаар сарын 25-ний өдрийн дотор, төлбөрийн акт, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НӨАТ тайлангаарх борлуулалтын орлого, санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогыг 88.0 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	88.0			1	88.0	1	88.0		
Дүн	1	88.0			1	88.0	1	88.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн гүйцэтгэх захиралд ТУЗ-ын тогтоолыг үндэслэн тэтгэмж олгосон	1	3.9	1	3.9				
Томилолтын зардал зам хоногоос тушаалын дагуу илүү олгосон	1	0.2	1	0.2				
МЦХК, мобиком, юнител, скайтелд тусламж, Аймгийн чуулганд оролцох сурагчдад дэмжлэгт зориулж хөрөнгө зарцуулсан	1	1.4					1	1.4
Шинэчлэгдэж батлагдсан НБББББ-ын үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа нь тухайн байгууллагад ашиглагддаг дулааны шугам, барилга байгууламжийн онцлогийг харгалзан тусгаагүй	1						1	
Хөвсгөл дуулга ХХК-тай шатах тослох материал нийлүүлэх гэрээний үнийг байгууллагын захирлын тушаалаар нэмэгдүүлэн тооцсон	1	0.6			1	0.6		
Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	57.7			1	57.7		
дүн	6	63.8	2	4.1	2	58.3	2	1.4